

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 87.11 дэх хэсэг нэмсүгэй:

“87.11.Дотоод, гадаадын цагдаагийн их, дээд сургуульд суралцаж байгаа цагдаагийн алба хаагчид цалин хөлс олгох журмыг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг